

ЗӨВШӨӨРӨВ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ

0128921 0024015028

БАТЛАВ

ДАРХАН-УУЛ ДАРГА

АЙМГИЙН ЗАСАГ

Б.АЗЖАРГАЛ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01/2024

Дархан хот

Д/д	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэслэл:</p> <ol style="list-style-type: none">“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан);Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020 онд батлагдсан);Хот байгуулалтын тухай хуулийн 10.1.7 дугаар заалт (2008 онд батлагдсан);Газрын тухай хуулийн 4.1.6, 19.1.8, 20.1.2, 20.2.3, 21.4.1, 23.3.1, 23.3.5, 25.3, 52.1, 55.1 дүгээр заалтууд (2002 онд батлагдсан);“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан);“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” (Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан);“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” (Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан);“Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр” (Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан);Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2018 онд батлагдсан);Дархан-Уул аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2016 онд батлагдсан);Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2/07 дугаар тогтоолоор батлагдсан);Дархан-Уул аймгийг 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө (Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 44 дүгээр тогтоолоор батлагдсан)
2	Ажлын зорилго,	Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжин тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,

	шийдвэрлэх асуудал	улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон салбаруудын онцлогтой нягт уялдуулсан, иргэд, олон нийтийн оролцоог хангасан дунд хугацааны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад оршино.
3	Тавигдах шаардлага.	<p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөний баримт бичиг нь тухай орон нутгийн онцлог, хөгжлийн чиг хандлага, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байх; 2. Улс орны хөгжлийн бодлого, зорилт, арга хэмжээг тухайн аймагт хэрэгжүүлэх, газар, түүний нөөц баялагт сууринсан хөгжлийн цогц төлөвлөлт хийсэн байх; 3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байх; 4. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан бүс нутаг, аймгийн түвшинд тусгагдсан асуудлыг бүхэлд нь хамруулан нарийвчлан тусгасан байх, ингэхдээ цогц байдал, орон нутгийн ялгаат байдал, тэргүүлэх чиглэл, харилцаа холбоо зэрэг асуудлыг бүрэн тооцсон байх; 5. Төлөвлөгөө боловсруулах арга хэрэгсэл нь шинжлэх ухаанд түшиглэсэн, мэдлэгт сууринсан, бүсчилсэн хөгжил, нутаг дэвсгэрийн цогцолбор хөгжлийн нийтлэг зарчмыг баримталсан байх; 6. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, ногоон хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн зарчмуудыг хангах асуудлыг шийдвэрлэсэн байх; 7. Зэрлэг ан амьтан, ховор, нэн ховор амьтдын амьдрах орчныг алдагдуулахгүй байх; 8. Төлөвлөх арга зүй нь бүсчлэлийн зарчимд сууринсан байх; 9. Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа газар нутгийн ландшафт төлөвлөлтийн арга зарчимд тулгуурлан газрын төлөв байдал, чанарын бүс, газар ашиглалтын бүс, нийгэм-эдийн засгийн эрэлт хэрэгцээг хангахад тухайн бүсэд тавигдах шаардлагыг тогтоох; 10. Төлөвлөгөө нь газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээнд тулгуурласан сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний суурь судалгааг хийсэн байх; 11. Байгалийн нөөцийг үнэн зөв тогтоож, түүний нехцел, нөөцед тохируулан ашиглах горимыг тодорхойлон газар ашиглалтыг нутаг дэвсгэрийн хувьд ялгавартай ашиглах бодлогыг боловсруулах, тогтвортой газар ашиглалтыг бий болгоход чиглэсэн байх. Тухайлбал: Ашигт малтмалын орд, уурхайн байршлын бүсчлэлийг тогтоох; 12. Газрын төлөв байдал, чанарын үнэлгээний бүсүүд, тэдгээрт зөвшөөрөгдхөж аж ахуйн болон байгаль хамгаалах үйл ажиллагааны төрөл, чиглэл, дэглэм, горим, тавигдах шаардлагыг тодорхойлох; 13. Ур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөл, эрсдэл эмзэг байдлыг

		<p>даван туулах дасан зохицох асуудлыг тусгаж төлөвлөсөн байх;</p> <p>14. Газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын тогтвортой менежментийг дэмжихийн тулд ландшафтын тувшний (эсвэл экосистемийн) хандлага, газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын тархалтыг харгалzan үзэх;</p> <p>15. Төлөвлөгөөнд WOCAT зэрэг дэвшилтэт үнэлгээний арга хэрэгслийн үр дүнг харгалzan газар ашиглалтын уламжлал, сайн туршлага, тэдгээрийг хадгалан үлдэх боломж бололцоог нээн гаргасан байх;</p> <p>16. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь бусад салбаруудын төлөвлөгөө болон хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны үндсэн суурь болох;</p> <p>17. Бүх төрлийн масштабтай зургийг стандартын дагуу, газар зүйн мэдээллийн систем ашиглан Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан солбицол, өндер, тусгагд тулгуурласан байх;</p> <p>18. Шинжлэх ухааны дэвшилтэт технологи, норм норматив, стандартад үндэслэсэн байх;</p> <p>19. Байгаль, түүх, соёлын дурсгалт газар нутгийг хамгаалахад чиглэсэн байх;</p> <p>20. Төлөвлөгөөний баримт бичиг нь өөрийн гэсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, шалгуур үзүүлэлттэй, суурь түвшин, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа, хүрэх үр дүн нь тодорхой хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;</p> <p>21. Төлөвлөгөөний шийдэл, арга хэмжээг хувилбартайгаар төлөвлөж, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нелөөллийг тооцсон байх;</p> <p>22. Ил тод, иргэдийн оролцоог хангасан байх.</p>
4	Ажлын хамрах хүрээ	<p>Хамрах объект:</p> <ol style="list-style-type: none"> Дархан-Уул аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын нийт газрууд (327500 га) Аймгийн эдийн засаг, үйлдвэрлэл, аж ахуй, нийгмийн салбарууд <p>Хамрах субъект:</p> <ol style="list-style-type: none"> Аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн захиргааны байгууллагууд; Ард иргэд, малчид, тэдгээрийн бүлэг, нөхөрлөл, хоршоо, хуулийн этгээд; Төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн газрууд; Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа; Сав газрын захиргаа.
5	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>Эхлэх хугацаа: 2024 оны дугаар сарын-ний өдөр</p> <p>Дуусах хугацаа: 2024 оны дугаар сарын-ний өдөр</p>

6	Ажлын иж бүрдэл	<p>НЭГ.Суурь судалгаа мэдээлэл цуглуулж боловсруулах, бэлтгэл ажлын нэгдсэн тайлбар бичиг болон холбогдох зураг. (1-р бүлэг тайлбар бичиг) Үүнд:</p> <p>Бүх ангиллын газар ашиглалт, геологи болон хүрээлэн буй орчны суурь судалгаа</p> <p>a. Газар ашиглалтын судалгаа</p> <p>Өмнө нь хийгдсэн газрын нэгдмэл сангийн тооллогын мэдээнд өнөөгийн газар ашиглалтын судалгаа, агаар сансрын зураг болон хээрийн судалгаа тодруулалтын аргаар тодотгол сайжруулалт хийж зураглан хамгийн сүүлийн үеийн нэгдмэл сангийн ангиллын тооллого судалгааны мэдээллийг боловсруулж зураглана. Газрын нэгдмэл сан, эрхзүйн харилцаа үссэн нэгж талбариуд, хадлан, тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа газар, дахин эргэлтэд оруулах атаршсан газар, тариалангийн ангилалд шилжүүлэх атар газар, тариалангаас атар газарт шилжүүлэх газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай, түүний нөлөөгөөр эвдэрсэн газрын судалгаа (үүнд түгээмэл тархацтай ашигт малтмал болон бичил уурхайн газруудыг хамааруулна), улсын болон орон нутгийн чанартай зам, шугам сүлжээний газрын байршил, тусгай хамгаалалттай газар нутгийн байршил, хэмжээ, аялал жуулчлал, амралт сувиллын газрын судалгаа, байршлын мэдээлэл, түүх соёлын дурсгалт газрын байршил хэмжээ, албан бус суурьшлын мэдээлэл, бэлчээр ашиглалтын мэдээлэл улирлаар, бэлчээрийн талхагдал, бэлчээрийн даац, доройтсон бэлчээр, ашиглалтгүй бэлчээр, усжуулах шаардлагатай бэлчээрийн судалгаа, өвөлжөө, хаваржaa, зуслан, намаржaa, худаг уст цэгийн мэдээлэл г.м. (M1:100.000 буюу зохих масштабаар)</p> <p>b. Хүрээлэн буй орчны суурь судалгаа</p> <p><u>Газрын доройтол:</u></p> <p>Газрын доройтлын төлөв байдал, доройтлын хэлбэр, доройтлын эрчмийн зураг, харгалзах тоон мэдээлэл, аймгийн хэмжээний газрын доройтлыг үнэлсэн зураглал.</p> <p><u>Гадаргын ус /гидрологи/:</u></p> <p>Гадаргын усны тархалт, нөөц, байршил, ундарга, гол мөрний урсац бүрэлдэх эх, урсцын хурдын мэдээлэл.</p> <p><u>Хөрс:</u></p> <p>Хөрсний хэв шинж, бүтэц, тархалтын мэдээлэл. Монгол орны 1:100.000 харьцаатай хөрсний зураглалыг ашиглана.</p> <p><u>Ургамал:</u></p> <p>Ургамалжилт, ургамлын аймаг, ургамал зүйн ангиллын мэдээлэл (га-н ургац).</p> <p><u>Ой:</u></p> <p>Ойн нөөц, төрөл, байршлын мэдээлэл.</p> <p><u>Уур амьсгал:</u></p> <p>Байгаль цаг уур, уур амьсгал, түүний үнэлгээ, төлөв байдал ба өөрчлөлтийн мэдээлэл</p> <p>Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн судалгаанд үндэслэн гамшигт үзэгдлийн давтамж өндөр газрын зураглал үйлдэх.</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтеөс үүдэлтэй цаг агаарын гамшигт үзэгдлийн (ган, цөлжилт, зуд, шороон шуурга гэх мэт) давтамжид дүн шинжилгээ хийж, орон зайн тархалтыг зураглах.</p>
---	-----------------	--

Амьтан:

Зэрлэг амьтны тархац, байршил, нүүдлийн зүйлүүдийн төллөх болон үржлийн үеийн амьдрах орчны холбоос нутаг, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутаг.

Туух, археологи, өв соёл:

Палеонтологи, археологийн олдвор, үл хөдлөх эд өлгийн зүйлс, тэдгээрийн байршил, хамгаалалтын бүсийн мэдээлэл

в. Геологийн суурь судалгаа

Геоморфологи:

Газрын гадаргын хэв шинж, налуу, хэрчигдэл, өндөршил, налуугийн чиглэлийн мэдээлэл.

Инженер геологийн нөхцөл:

Одоо байгаа сүм, суурин газруудын суурьшлын бүсүүдийн инженер, геологийн нөхцөлийн судалгаа, мэдээлэл

Гүний ус (Гидрогеологи):

Уст цэг, инженерийн барилга байгууламж бүхий газруудын ерөнхий зураглалыг харуулах, бэлчээр газар тариалан, олборлох үйлдвэр, хүн амын усан хангамжийн нөхцөлийг тодорхойлох.

Гамшигийн эрсдэлийн судалгаа

Үер, гал түймэр, газар хөдлөлт гэх мэт байгалийн гамшигт өртөгдхөх эрсдэлийн судалгааны мэдээллийг ашиглан хот суурин газар бүрээр гамшигт өртөгдөх болзошгүй газруудын байршлыг тогтоох.

г. Хүрээлэн буй орчин, газар ашиглалтын одоогийн байдалд үнэлгээ хийх

- Хот, тосгон, бусад суурин газрын орчны бохирдлын мэдээлэлд анализ хийж, үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох;
- Газрын доройтол (хөрсний элэгдэл, ялзмаг болон шим тэжээлийн алдагдал), бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайн сөрөг нөлөөллийн тооцоо судалгаа, газрын байршил талбайн хэмжээг тодорхойлж, зураглах, үнэлэх;
- Тариалангийн талбайн салхи, усны элэгдэл, үржил шимиин алдагдал тодорхойлох;
- Бэлчээрийн газрын өөрчлөлтийг үнэлэх фото мониторингийн судалгааны мэдээлэлд үндэслэн бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх;
- “Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар”-ыг ашиглан бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох;
- Зам шугам сүлжээний газрын зэрлэг амьтны байршил, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, малчдын нүүдэлд учруулж буй бэрхшээлийн судалгаа, зураг;
- Ойн ашиглалтаас байгаль орчны тэнцвэрт байдалд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгаа, зураг;
- Газар ашиглалтаас усны нөөцийн хомсдол, бохирдолд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгаа зураг;
- Аймгийн хэмжээнд нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын талбайн өөрчлөлтийг 2000 оноос хойш өнөөг хүртэлх хугацаагаар гаргаж хүснэгт болон графикаар харуулж, зөрүүг эхний 10 жилтэй сүүлийн 10 жилийг харьцуулж гаргах;
- ГЗБГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар

		<p>баталсан тушаалын дагуу дараах тохиромжтой байдлын үнэлгээнүүдийг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ; - Бэлчээр, хадлан, тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ (сумын төв, суурин газрын одоогийн тэг гортиг тэлэх боломжит газруудын үнэлгээ); - Шугаман байгууламж байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой газрын үнэлгээ; <p>11. Нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээ хийх.</p> <p>Нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг эдийн засаг, үйлдвэрлэлийн салбар бүрээр болон иргэдийн эрэлт хэрэгцээний чиг хандлагыг тогтоох (SWOT) болон бусад шинжилгээ хийнэ.</p> <p>Нийгэм, эдийн засгийн хэрэгцээг дараах чиглэлээр тодорхойлж, түүнд шаардагдах газрын хэмжээг тооцоолох:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ (сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт төрийн байгууллага, халуун ус гэх мэт үйлчилгээний бусад газар, ногоон байгууламж, цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэгцээ) - Шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын хэрэгцээ - Ажлын байрны хэрэгцээ шаардлага (салбар бүрээр) - Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ - Хадлан, малын тэжээлийн ургамлын хэрэгцээ - Худаг, усан сангийн хэрэгцээ <p>ХОЁР. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг (2-р бүлэг тайлбар бичиг)</p> <p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг нь энэхүү ажлын даалгаварт тусгагдсан техникийн шаардлагыг хангасан дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2.1. Үндэслэл 2.2. Зорилго, зорилт 2.3. Геологи болон хүрээлэн буй орчны судалгаа 2.4. Газар ашиглалтын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээ 2.5. Нийгэм, эдийн засгийн судалгаан дээр үндэслэсэн газрын эрэлт хэрэгцээний чиг хандлага 2.6. Байгалийн нөөц ашиглалтын дэглэм, хамгаалалтын бүс 2.7. Улсын болон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичгээс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ үйл ажиллагааны төлөвлөлтийг хийх. 2.8. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалд дүн
--	--	--

	<p>шинжилгээ хийж аймгийн улс, бус нутгийн хэмжээнд нийгэм, эдийн засагт үзүүлэх нелөө, гүйцэтгэх үүрэг, чиглэл, аймгийн нийт сумдын аймгийн нийгэм, эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжилд үзүүлэх нелөө тэргүүлэх чиглэл, ач холбогдол, төрөлжилтийг тодорхойлж, тэдгээрийг дэмжих газрын харилцааны бодлого үйл ажиллагааг тодорхойлж, арга хэмжээг төлөвлөх.</p> <p>2.9. Улсын болон хиллэж байгаа аймгуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй тухайн аймгийн хөгжлийг уялдуулан газар зохион байгуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх талаар шийдэл, санал боловсруулах.</p> <p>2.10. Хот суурин газрын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> - Сумын төвүүдийн бүлэг суурины дэд бүтцийн сүлжээ, нийгэм, соёл ахуйн үйлчилгээний зохистой хүрээ, харилцан таталцлын хамаарлыг тооцож, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох; - Аймгийн төвийн сумын хот суурин газрыг хүн амын өсөлтийн үзүүлэлт дээр үндэслэн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөнүүдтэй уялдуулан инженерийн шугам сүлжээ бүхий газрын байршил, хэмжээ хил, заагийг тодорхойлон, түүний ашиглалтын функциональ бус түүний доторх иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад олгох газрын хэмжээ, байршил, зориулалтыг төлөвлөх; - Одоо байгаа сумын төв, тосгон, суурины эдэлбэр газар, тэг гортигийг тэлэх болон шинээр суурьшлын бус үүсгэж хот, тосгон бусад суурины ангилалд шилжүүлэх газрын нөөц, хэмжээ байршил зориулалтыг газрын хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээ, орон нутгийн саналд үндэслэн тогтоож төлөвлөх; - Хот тосгон бусад суурины газраас бусад газарт шинээр байгуулах хүнд, хөнгөн үйлдвэрийн схемчилсэн байршил, хэмжээ хил заагийг зураглах; - Олон улс, улсын чанартай, тусгай зориулалтын авто зам дагуух газарт бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түшиглэн суурьшлын бус, амралт, үйлчилгээний бүсийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ ашиглан оновчтой байршлыг тодорхойлох; - Сумын төв, суурин газруудын ойролцоо хог хаягдлын ангилан ялгалттай нэгдсэн хогийн цэг байгуулах газруудыг тогтоож төлөвлөх; - Үер, гал түймэр, газар хөдлөлт, ган, зуд гэх мэт байгалийн гамшигт өртөгдөх эрсдэлтэй хот суурин газрыг тодорхойлж, авах арга хэмжээг төлөвлөх; - Ашигт малтмалын орд, уурхайн байршлын бүсчлэлийг тогтоож түүнд түшиглэн бий болох дахин боловсруулах томоохон үйлдвэрүүдийн байршлыг төлөвлөх. <p>2.11. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> - Доройтолд өртсөн бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэлд шаардлагатай тухайн нутгийн экологийн нөхцөлд тохирсон бэлчээрийн олон наст ургамлын үр үргүүлгийн талбайн байршлыг төлөвлөх; - Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа бэлчээрийн фото мониторингийн судалгаанд үндэслэлж "Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар"-ыг ашиглан
--	---

		<p>бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн төлөв байдлыг сэргэх чадавхын ангиллаар байршлын зураг гаргаж талбайн хэмжээг тодорхойлох; - Бэлчээрийн ургац, бэлчээрийн талхагдал, бэлчээрийн сэргэх чадавх зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн бэлчээрийн сэлгэх, өнжөөх болон сайжруулах, хамгаалах шаардлагатай бэлчээрийг орон нутгийн санал болон хээрийн судалгааны ажлаар таарцыг шалган бэлчээрийн нөхцөл нөөцийн төлөвлөлтийг хийж гүйцэтгэх; - Төлөвлөлтийн хугацааны газрын нөөц, чадавх, бэлчээрийн даац, мал сүргийн эргэлттэй уялдуулан аймгийн хэмжээний мах, сүү, ноос, ноолуур, арьс шир, дайвар бүтээгдэхүүн гэх мэт мал аж, ахуйн бүтээгдэхүүн, таваарын үйлдвэрлэлийн хэтийн төлөвийг тооцоолж, тэдгээрийг хадгалах, боловсруулах, борлуулах хөдөө аж ахуйн үйлдвэр, кластер, тэдгээрийг байгуулах газрын байршил, хэмжээг төлөвлөх; - Цаашид доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээр ашиглалтыг, бэлчээрийн сэргэх чадавхад суурилан ашиглалтын зөвлөмж боловсруулах, бэлчээрийг сайжруулах, хамгаалах арга хэмжээг төлөвлөх; - Бэлчээрийн даацыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд болон цэвэр бэлчээрийн газарт тооцож, зураглах; - Төлөвлөлтийн хугацаанд сүргийн эргэлт, зохистой бутцийг тооцоолж бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойг тооцож гаргах; - Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зураглал гаргах; - Өвөл, хавар, зун, намрын бэлчээрийн хил зааг, түүнийг сэлгэн ашиглах хуваарь түүний байршил, талбайн хэмжээг тодорхойлох; - Мал тууварлах, бэлчээх зорилгоор бусдын газрыг дамжин өнгөрөх сервитут эрх тогтоох бэлчээрийн зурvas газрын хэмжээ, байршил хил заагийг мал эмнэлгийн хяналтын цэгүүдтэй уялдуулан тогтоох; - Мал амьтны гоц халдварт өвчин гарсан голомтот цэг, байршлыг тусгайлан бүртгэлжүүлж тухайн газарт үйл ажиллагаа явуулахыг хориглож хязгаарлах; - Эрчимжсэн, хагас эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бус байршил, хэмжээ, түүнд баримтлах бодлого, газар ашиглалтын шаардлагыг тодорхойлж, төлөвлөх; - Эрчимжсэн, хагас эрчимжсэн аж ахуй эрхлэх нутаг дэвсгэрт мал бордох цэгүүдийг орон нутгийн саналд үндэслэн төлөвлөх; - Орон нутгийн түвшний эрчимжсэн мал, амьтны аж ахуй эрхлэх, агро технологийн тэрэлжсэн парк байгуулах нутаг дэвсгэрийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл тооцооллыг хийж гүйцэтгэх; - Хадлангийн зориулалтаар ашиглаж байгаа болон цаашид ашиглах газрын байршлыг төлөвлөх; - Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэх хадлангийн газрыг орон нутгийн саналд үндэслэн төлөвлөх; - Сум дундын болон сумын отрын нөөц бэлчээрийг тодорхойлж, газрын байршил, талбайн хэмжээг тодорхойлох;
--	--	---

- Тариалангийн бус нутгийн байршил, хэмжээ, түүнд баримтлах бодлого, газар ашиглалтын шаардлагыг тодорхойлж, төлөвлөх;
- Орон нутгийн чанартай услалтын систем, ус дамжуулах хоолой байгуулах газар, усалгаатай болон усалгаагүй ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх бус нутгийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл, тооцооллыг хийх;
- Одоо ашиглаж байгаа тариалангийн газрыг тэлж нэмэгдүүлэх боломжит хэмжээг тогтоох;
- Дахин эргэлтэд оруулах атаршсан газар, тариалангийн ангилалд шилжүүлэх атар газрын байршил, хэмжээ, хил заагийг таримлын үйлдвэрлэл эрхлэх тэрлөөр нь төлөвлөх /тариаланд шилжүүлэх атар газрыг газар дээр нь хэмжилт, тодруулга хийж, хөрсний зүсэлт хийж тариаланд тохиromжтой байршлыг тодорхойлно./;
- Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурvas байгуулах шаардлагатай газруудын төлөвлөлт;
- Тариалангийн газрыг дахин зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх газрын хэмжээ, байршлыг төлөвлөх.

2.12. Усны сан бүхий газрын төлөвлөлт

- Худаг, уст цэгийн байршлыг тогтоож, гүний болон гар худаг гаргах газрын байршлыг зураглах;
- Гадаргын усны хамгаалалтын бүсийг тогтоох, зураглах;
- Хөв, цөөрөм байгуулж, гадаргын усыг цуглуулах газрыг тодорхойлж зураглах;
- Усан хангамжийн ирээдүйтэй талбайн цэгийн байршлыг тогтоох,
- Сум суурин газарт хүн амын ундны цэвэр усны нэгдсэн сан, цэвэрлэх байгууламж баригдах газрын асуудлыг ерөнхий төлөвлөгөөнд тусгах.

2.13.Ойн сан бүхий газрын төлөвлөлт

- Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсүүдийг тогтоож, нөхөн сэргээх, цаашид авах арга хэмжээг холбогдох газартай хамтран төлөвлөх;
- Цөлжилтөөс хамгаалсан ойн зурvas байгуулах газрын байршил талбайн хэмжээг гаргаж төлөвлөх;
- Мод үржүүлгийн газруудын байршлыг зураглах, төлөвлөх;
- Ойн зурваст уст цэг бий болгох газруудын байршлыг төлөвлөх;

2.14.Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт

- Тусгай хэрэгцээний газрыг дэд ангилал бүрээр төлөвлөх;
- Тусгай хэрэгцээнд болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар, түүх, соёлын дурсгалт газар, биологийн олон янз байдлын чухал амьдрах орчин, тэдгээрийн холбоос нутгийг төлөвлөх, өргөтгөх, шинээр авах, гаргах газрын байршил хэмжээ, хил заагийг үндэслэлийн хамт төлөвлөх (үндэслэлийг тодорхой оруулах);
- Тухайн аймагт байгаа улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орон нутгийн хэрэгцээ шаардлага, эрх зүйн орчинд нийцүүлэн тусгай хамгаалалттай газар нутгуудын газар ашиглалтын төлөвлөлт хийх.

		<p>2.15. Зам шугам сүлжээний газрын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн газар, мал амьтны коридор нүүдэлд саад болж буй замын байршлыг зураглаж, авах арга хэмжээг төлөвлөх; - Авто замын сүлжээний төлөвлөлтийг зураглах, энэхүү төлөвлөлт нь зэрлэг амьтад болон малын нүүдлийн зам, биологийн олон янз байдлын чухал амьдрах орчин тэдгээрийн холбоос нутаг, тариалангийн талбайг аль болох дайран өнгөрөхгүй байхаар зураглах, дайран өнгөрөх тохиолдолд эрсдэл учруулахгүй байлгах арга хэмжээг төлөвлөх; - Авто замын тээврийн сүлжээ, аймгийн хэмжээний ачаа эргэлтийн өнөөгийн болон хэтийн төлөвийг тооцоолох; - Авто замын байгууламж, тээвэр логистикийн төвүүдийн байршлын төлөвлөлтийг зураглах; - Засаж сайжруулах зам, гүүрний байршлыг зураглах. - Авто замын аюулгүйн болон хамгаалалтын бүсүүдийг зураглаж ирээдүйд газрын нэгдмэл санд гарах өөрчлөлтийг тооцоолох; - Холбоо мэдээллийн шугам татах газрын байршил, хэмжээг зураглах; - Эрчим хүчний сүлжээ, үйлдвэрлэлийн байгууламж барих газрын байршил, хэмжээг зураглах. - Нисэх онгоц аэродромын газар төлөвлөх, хамгаалалтын бүсийг тогтоох, зураглах <p>2.16. Аялал жуулчлалын газрын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хил зааг, байршил хэмжээг зураглаж төлөвлөх; - Аялал жуулчлалын төрлийг гаргаж, төрөл тус бурд маршрут гаргах; - Аялал жуулчлалын объект бүрт аялагчдад үзүүлэх үйлчилгээг тодорхой тусгах; (үзэсгэлэнт газар, түүх соёлын үзмэр, Монгол уламжлалт мал аж ахуй, Морин өртөөний газар төлөвлөх, г.м) ; - Аялал жуулчлалын бүсийг тохиромжтой байдлын үнэлгээ ашиглан оновчтой байршлыг тодорхойлох; - Жуулчны бааз, амралтын газрын зориулалтаар эзэмшиүүлэх газрын байршил, хэмжээг зураглах; - Аймгийн хэмжээнд хэрэгжихээр төлөвлөгдөж буй төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан аялал жуулчлалын төрөл, маршрутыг гарган, байршил хэмжээг зураглах. - Кино урлагийн зураг авалтын полигон төлөвлөх, цаашид жуулчдад үзүүлэх аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох газрыг төлөвлөх <p>2.17. Үйлдвэр, уурхайн газрын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> - Улсын газар зохион байгуулалтын өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйлдвэр уурхайн газар болон тэдгээрт түшиглэсэн түүхий эдийн боловсруулах үйлдвэрүүдийн байршлыг, нөлөөллийн бүсийн хамт зураглах; - Аймгийн төв болон бусад сумын Хот байгуулалтын хөгжлийн өрөнхий төлөвлөгөө, сумын түүхий эдийн нөөц боломжид тулгуурласан үйлдвэр технологийн парк, хүнд үйлдвэрийн байршлыг зураглаж, авах арга хэмжээг төлөвлөх;
--	--	--

		<ul style="list-style-type: none"> - Уул уурхайн нөлөөлөлд өртөж эвдэрсэн газрыг тодорхойлж зураглах, газрын чанарын хянан баталгаа хийх газруудыг тодорхойлох; - Ухагдаж эвдэрсэн газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар төлөвлөх (Бичил уурхайн газруудтай уялдуулах); <p>2.18. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, мөн хангалтгүй (зохицуулалтгүй төлөвлөлтөөс үүдэн ирээдүйд байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх) нөлөөллийг багасгах зорилгоор Байгаль орчин ба нийгмийн менежментийн хүрээ (ESMF)-нд эрсдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>2.19. Усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө, ойн менежмент, бэлчээрийн менежмент эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, түүнчлэн холбоос нутаг, нүүдлийн зүйлийн талаар хийсэн судалгааны үр дүнд тогтоосон газар нутгууд гэх мэт тусгай салбарын менежментийн төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тусгах;</p> <p>2.20. ГЗБГЗЕГ-ын бичгээр гаргасан техникийн дүгнэлтийг ажлын явцын болон эцсийн тайлангийн тесөлд тусгаж, эцсийн тайланг аймгийн ИТХ-д батлуулахаар танилцуулах;</p> <p>2.21. Аймгийн ИТХ-аар баталсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад баримт бичгийн хамт холбогдох байгууллагад хүргүүлэх;</p> <p>2.22. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал хооронд шилжүүлэх газрын байршил, хэмжээ, хил зааг, уг ажлын хүрээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлын төрөл, төсөвт өртгийн тооцоо;</p> <p>2.23. Төлөвлөлтийн үр дүнд газрын нэгдмэл санд орох өөрчлөлтийг харуулсан аймгийн хэмжээний нэгдсэн экспликацийг гаргах;</p> <p>2.24. Олон нийтийн оролцоог хангасан материал /хэлэлцүүлэг явуулсан, санал авсан материал, уулзалтын тэмдэглэл, фото зураг, төлөвлөгөөг баталгаажуулсан шийдвэр/;</p> <p>2.25. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 57 тоот тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн хавсралт 3-н дагуу төлөвлөгөөний шийдэл, арга хэмжээ, үйл ажиллагаа бурийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах төсөв зардал түүний эх үүсвэр, оролцогч талууд тэдгээрийн үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж хийсэн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хавсралтаар батлуулах;</p> <p>2.26. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем болон www.egazar.gov.mn цахим хуудсанд байршиж, баталгаажсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тесэл;</p> <p>2.27. Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3-д заасны дагуу газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан дүгнэлт;</p>
--	--	--

		2.28.Захиалагчийн хяналтын дүгнэлт.
7	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Газрын нэгдмэл санд буртгэлтэй Дархан-Уул аймгийн нийт газар нутаг болох 327500 га талбай хамарна.
8	Гүйцэтгэх ажлын үе шат	<p>Ажлыг дараах үе шатаар гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Суурь судалгааны анхдагч мэдээлэл цуглуулах, дүгнэлт гаргаж нэмж судлах төлөвлөгөөг гаргах, газар дээр нь очиж тодруулга хийх, анхдагч мэдээлэл, судалгааны материалыг боловсруулж нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх /Бэлтгэл шатны тайлан/; Орон нутгийн териийн байгууллагууд, ард иргэдийн оролцоог хангах (Хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга, судалгаа авах) /Хээрийн судалгааны тайлан/; Төлөвлөгөөний эхний хувилбарыг боловсруулах; ГЗБГЗЗЕГ-ын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авч, дүгнэлт гаргах; Захиалагч байгууллага болон орон нутгийн териийн байгууллагуудаас санал авах, зөвшилцэх, хянуулах, дүгнэлт гаргуулах; Хэлэлцүүлэг, санал авах, дүгнэлт гаргах явцад гарсан саналаас шаардлагатайг тусган төлөвлөгөөний эцсийн хувилбарыг боловсруулах; АГЗБЕТ-ний эцсийн хувилбарыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээс өмнө ГЗБГЗЗЕГ-ын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах; Гэрээний дагуу батлагдсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг захиалагч болон хэрэглэгч байгууллагад хүлээлгэн өгөх; Гэрээг дүгнэх, төлбөр тооцоог дуусгах.
9	Техникийн шаардлага, заавар	<p>Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад дараах техникийн шаардлагыг баримтлан ажиллана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Төлөвлөлтийн зургийг Монгол улсын стандарт "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг"; MNS 6316:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:25000, 1:50000, 1:10000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6317:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:1000000 Масштабын зургийн таних тэмдэг" MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт; БХБ-ын сайдын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 57 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмж"; Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"; ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан "Газар тохиромжтой байдлын үнэлгээ боловсруулах аргачлал" ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/134 дугаар тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргазүй" ГЗБГЗЗГ-ын даргын 2020 А/40 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн

		<p>цахим систем ажиллуулах журам"</p> <p>6. ГХГЗЗГ-ын даргын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 224 дугаар тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам"</p> <p>7. 1997 оны Геоэкологийн хүрээлэн, Газрын хэрэг эрхлэх газрын хамтран боловсруулсан "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх ажлын заавар"</p> <p>Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад дараах зааврын дагуу ажиллана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Судалгааны болон төлөвлөлтийн зургийн байрлалыг WGS-84 солбицлын системд, өндрийг Балтын тэнгисийн өндрийн системд тус тус гүйцэтгэнэ. Бүх төрлийн дүн шинжилгээг стандарт аргачлалын дагуу хийсэн байна. Заавал мөрдөх акт, нотлох баримт, тэмдэглэлийг үйлдсэн байна. Гүйцэтгэгч байгууллага нь төлөвлөгөөний үе шатны гүйцэтгэлийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тухай бүр тайлagnana. Газрын төлөв байдал, чанарын үнэлгээний бүсүүд, тэдгээрт зөвшөөрөгдөх аж ахуйн болон байгаль хамгаалах үйл ажиллагааны төрөл, чиглэл, дэглэм, горим, тавигдах шаардлагыг тодорхойлно. Төлөвлөгөөний зураг төслийн үзүүлэлтийг төлөвлөлтийн өмнөх болон дараах үзүүлэлтээр гаргана (Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 57 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн Хавсралт 2-н дагуу). Төлөвлөгөөний тайлан, судалгаа, тоон зураг болон бусад холбогдох материалыг тоон хэлбэрээр ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулж, www.eغازار.gov.mn сайтад нээлттэй байршуулсан байна. Төлөвлөгөөний зураг төслийн хүрэх үр дүн нь шалтуур үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна. (Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 57 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн хавсралт 3-ын дагуу) Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний эцсийн дүгнэлт, саналыг өгч, ажил шалгасан акт, ажил хүлээн авсан акт үйлдсэнээр ажлыг дууссанд тооцно.
10	Ажлын хяналт, шалгалт	Захиалагчийн техникийн хяналтын зардал нь нийт зардлын 5 хувь байна. ГЗБГЗЗЕГ болон аймгийн ГХБХБГ нь хамтран аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэнэ.

		<p>Захиалагчийн техникийн хяналтын зардлын 80 хувьтай тэнцэх зардлаар аймгийн ГХБХБГ, 20 хувьтай тэнцэх зардлаар ГЗБГЗЗЕГ тус тус захиалагчийн техникийн хяналт хийх ажилд зарцуулна. Захиалагчийн техникийн хяналтыг дараах ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. ГЗБГЗЗЕГ нь аймгийн ерөнхий төлөвлөгөөг улс, бүсийн чанартай хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байдал, төлөвлөгөөг холбогдох журам, заавар аргачлал, ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал, төлөвлөлтийн болон суурь судалгааны газар зүйн мэдээллийн санг тоон хэлбэрээр үүсгэсэн байдалд хяналт хийж, явцын болон эцсийн тайландаа мэргэжлийн дүгнэлт гаргана, шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллаж хяналтыг гүйцэтгэнэ. 2. Аймгийн ГХБХБГ-аас гүйцэтгэгч байгууллага ерөнхий төлөвлөгөө боловсруулахад аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль хамгааллын салбаруудын дэд хөтөлбөр, төлөвлөгөө, стратегитай хэрхэн уялдах, иргэд, олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийх ажлыг гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэгч хээрийн хэмжилт судалгаа, орон нутагт хэлэлцүүлэг хийх зэрэг үе шатны бүхий л үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, явцын болон эцсийн тайлангийн төсөлд дүгнэлт гарган тухай бүрт ГЗБГЗЗЕГ-т ажлын явцыг тайлagnаж ажиллана. 3. Орон нутаг дахь бүх салбарын төрийн байгууллагууд, иргэдийн байгууллага (иргэдийн Төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурал, төрийн бус байгууллага), иргэдээс санал авч, мэдээлэл танилцуулга хийсэн байна.
11	Хүлээлгэн өгөх материал	<p>Төлөвлөгөөний иж бүрэн материалыг (суурь судалгааны тайлан, төлөвлөгөөний тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, мэдээллийн сан, холбогдох зураг, (DVD)) дараах байгууллагад тус бүр 1 хувийг хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал; 2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс; 3. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар; 4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Архив, мэдээллийн хэлтэс; <p>Тайлан, мэдээллийг хүлээлгэж өгөхдөө ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, баримт хүлээн авах журам, ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам", Ерөнхий төлөвлөгөөний тоон зургийн мэдээллийн санг хүлээлгэн өгөхдөө ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ыг тус тус баримтална.</p>
12	Захиалагч байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Аймгийн Засаг даргын Тамгын газар 2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

13	Гүйцэтгэгч байгууллага	Газар зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын эрх бүхий байгууллага байна.
14	Санхүүжилт, эх үүсвэр	<p>1. Төлөвлөгөө боловсруулах үе шат бүрт Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас явцын дүгнэлт гаргуулж акт үйлдсэний дараа санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.</p> <p>2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах төсөв зардлын 5-аас доошгүй хувийг ажлын үе шатны гүйцэтгэлийн явц, чанарыг шалгах шинжээчдийн баг ажиллуулахад зарцуулна.</p> <p>3. Аймгийн 2024 оны төсвөөс дараах хуваарийн дагуу санхүүжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 3.1. Эхний санхүүжилт - 40 хувь (Гэрээ байгуулсны дараа) 3.2. Хоёр дахь санхүүжилт - 40 хувь (Эхний шатны төлөвлөгөөний тайлбар бичиг, мэдээллийн санд өгсөн дүгнэлт гарсны дараа) 3.3. Эцсийн санхүүжилт - 20 хувь (Ажил хүлээлгэн өгсний дараа)
15	Ажлын онцгой нөхцөл	Орон нутгийн ба улсын тусгай хамгаалалттай газар ажиллах бол зөвшөөрөл авах.
16	Төрийн нууцыг хадгалах хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам.
17	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ
ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ИХБАЯР

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАТСУХ

Д.БАТЧУЛУУН

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ
ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.ГЭРЭЛТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАЗРЫН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.НЯМДОРЖ

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



М.ДАРЬСҮРЭН